

**Ү НОЁН ХУТАГТ ДАНЗАНРАВЖАА БОЛООД ҮИ ДАЛАЙ ЛАМ
ЦАНЬЯНЖАМЦЫН БҮТЭЭЛ ТУУРВИЛЫН УЧИГ ХОЛБОГДОЛ**

До.Цэнджав *

ТҮЛХҮҮР ҮГ: Ү ноён хутагт Дулдуйтын Данзанравжаа, ҮИ Далай лам Цаньянжамц хоёр хайрын дууч, агаар нэгэн буй, дээд лам хуврагаас гарахын аргагүй янаг амрагийн сэдэв, Монгол, Төвдийн яруу найргийг шинэчлэгч, иргэний чөлөөт сэтгэлгээт, ад шоо үзэгчсэд

Монгол шүлэг, зохиол хэдэн зууны турш бурхан шашны агуулгатай, сургаалийн өнгө аястай номлогчийн байр суурьтай байсаар ирснийг Говийн ноён хутагт Данзанравжаа огцом өөрчилж, үндэсний уламжлалт яруу найрагт цоо шинэ шинэчлэл хийсэн юм. Данзанравжаа дээд зиндааны хутагт хувилгаан боловч тухайн нийгмийн онол үзэл, бурхан шажны номлол сургаал, хуврага лам хүний ёсзүй шагшаабаттай зөрчилдөж өнөөгийн томъёоллоор “иргэний уянгын” гэж бүрэн болох шүлгээр тухайн нийгмээ цочирдуулан гайхшируулсан асар том шинэчлэлийг хэрхэн яаж хийв? Хутагтаас өмнө өөр номын гэгээнтэн хэдэн зуугаараа байсан ч ийм байж боломгүй гэмээр санаанд оршгүй, саванд багтамгүй янаг амрагийн “эрээ цээргүй” шүлгийг хэн зохиов? судар номын хуудсан дээр байтугай сураг чимээ чихэнд дуулах нь ч бузар булай, ад тийрэн, цээрлэм увайгүй мөр бадаглалыг хэн анх буй болгоов? гэсэн асуулт сонирхол татна, тэр үедээ шүү. Бурханы шавь лам хуврагуудад ийм винайн ёсыг хатуу чанд баримтлахыг номлолоо болгодог “оюун сэтгэлгээний мүглэнгээс” цойлж гарч чадсан, шүлэг найрагт эрс шинэчлэл, өөрчлөлт хийж чадсан Монголын цорын ганц дээд гэгээнтэн, хутагт хувилгаан бол яахын аргагүй Дулдуйтын Данзанравжаа (1803-1856) мөн.

Харанхуй шөнө дунд агт морь янцгаах нь муу ёр бус

Харанхуй шөнө тойн хүн хурьцал эдлэх нь чухам муу ёр гэж цахар гэвш
Лувсанчүлтэм шүлэглэж байсан нь ерөөс лам нарын хувьд хатуу сануулга, баримтлах дэг ёс болж байв.

Ийнхүү урам зориг, итгэл үзэмшил төрсөн мэт шүлэг туурвисан нь хаанаас оюун санааны нөлөө тусгалыг авав? Ямар нэгэн дам, далд холбоо байв уу? гэсэн асуудал сонирхол татна. Үндэсгүй мод байдаггүйн адил уран зохиол, тэр тусмаа яруу найраг урд өмнөхийн уламжлалт санааны хүчтэй нөлөө тусгалаа олсоны үр дүн гэж үздэг. “Зохист аялгууны ухаанд” эгүүнээ тийм бүхнээ их мэргэд эртний дээдсийн

* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Утга зохиолын тэнхим

араас даган эгнэгт үзүүлсэн үгсийн ачаар энэ ертөнцийн ёсонд ормуй” гэсэн нь үүнийг илчилнэ.

Уран зохиолын онол практикт “Өмнөх үеийн аль нэгэн ном зохиолыг, зохиолчийг уншиж, ойлгож, мэдрэхгүйгээр нэг ч бүтээл туурвиж чадахгүй, тэр байтугай шинэчлэл ч хийж чадахгүй” гэсэн томъёолол хэдэн зуун дамжсаар ирсэн, одоо мөн тэгж л үзсээр байна. Ичимхий эгэл даруухан монголчуудад илэрхий шулуухан хэлчихсэн янаг амраг, хайр сэтгэлийн сэдэвтэй задгай сэтгэлгээт чөлөөт шүлэг өмнө нь байсангүй. Байхын ч аргагүйгээр төсөөлөгдөж байв. Харин түүнээс хориод жилийн хожуу төрсөн Ванчинбалын Гуларансын (1820-1851) “Сайхан хүмүүн” шүлэгт:

Өнгө чинү гурван хаврын тоорын цэцэг мэт

Үнэр чинь есөн намрын сүмэн өвс адил

Үсний хар эгнэгт бэхэсийн харыг даран чадаад

Үнэн улаан яахин чиний уруулын улааныг гүйцмүй

гэсэн мөртөд анхи залуу ургамал цэцэг адил охины далдын далд гоо үзэсгэлэн гэрэлтэж харагдсан мөрүүд байдаг. Гэхдээ энэ шүлэг янаг амрагийн харилцааны санааг ил шууд шулуухан илэрхийлсэн чөлөөт задгай сэтгэлгээний шүлэг биш, харин дорнын өнгө аястай, дотоод мэдрэмжийн хөг зохилдлого бүхий утга чимэглэн далдлах аргаар бичсэн шүлэг юм.

Тэгвэл хэн гээчийн суутны бүтээл туурвил нөлөөлсөн байх магадлалтайг эрж хайвал яахын аргагүй Цаст Төвдийн ҮИ далай Цанъянжамцын (1683-1747) шүлэг бүтээл “Янагийн дуулал” шүлгийн нөлөө эрхбиш байна гэх магадлалтай байгаа юм.

Нэгдүгээрт: Намтар товчоо нь түүхийн алтан хуудсанд мөнхөд бичиж үлдээдэг үе үеийн Далай ламд мөргөж шүтдэггүй мэддэггүй, бүх монголчууд тэр тусмаа ар өврийн нэгээхэн ч хутагт хувилгаан байхгүй гэдэгт итгэж болно. Данзанравжаагийн шүлэгт:

Далай ламын адислалаар

Дайн дайсныг устгаад

Давхар баяр болохыг

Дарнат өршөө гэсэн мөр “Хөвчийн өндөрт” байдгаас ч үзэхэд тодорхой байна.

Хоёрдугаарт: Далай ламын сургаал номлолыг барагтай дагадаг, номын мэргэд үзээгүй хараагүй томоохон хурал номын хийд, лам хувраг байхгүй.

Гуравдугаарт: Тавдугаар ноён хутагт Данзанравжаа баруун зүгт дөрвөд Далай хан, умар зүгт хангай хан, Орхон сав нутаг, Сэцэн ханы нутаг, өвөрлөгч түмний олон нутаг хошуу Алшаа, Долнуур, Хөх хот, Төвдийн Амду, Их Хүрээ зэрэг олон арван орон нутгаар аялан явж, бодол санаа, оюуны асар их эрч хүч авч, соёл, ном бүтээлийг шохоорхон судалж, цуглуулан авч, биет болон биет бус өвтэй холбоо хэлхээтэй явж ирсэн жинхэнэ эрх чөлөөт уран бүтээлчийн хувь заяагаар амьдарсан хүн. Төвдийн зохиолч Лувсанданбийжанцаны зохиосон “Саран хөхөөний туужийг” дай гүүш Агванданпэл 1770 онд монгол хэлээр орчуулсныг арга залиар сүүхээчилэн олж, Равжаа хутагт урнаар сэтгэж, бүлэг нэмж “Саран хөхөөний намтар” дуулалт жүжгээ зохиосон түүхтэй. Энэ бүхнээс үзвэл, хар багаасаа төвд хэлний чанадад нэвтрэн гарамгай болсон тэрбээр номт гурван гүрний нэг Төвдийн ном соёлыг шимтэн дээр нь өөрийн эш онолыг нэмэн баяжуулж байв. Энэ замд Далай лам Цанъянжамцын “Янагийн дуулал” (Ц.Дамдинсүрэнгийн орчуулга) “Чихний чимэг хайрын дуун” (Төвд эх, англи, хятад орчуулгыг тулган хөрвүүлсэн

М.Шагдарсүрэнгийн орчуулга) санаа сэдлийг анх сэтгэлд нь үүсгэж, оюуныг тэжээж шүлэглэлийн нөлөөлөгч, сэдрээгч, мэдрүүлэгч, шунахайран дурлуулагч нөлөө үзүүлсэн нь шүлгүүдийг хооронд нь харьцуулан үзвээс сонирхол татна. Энэ хоёр гэгээнтэн хувилгааны янаг амраг, хайр сэтгэлийн шүлэг түүхэн орчил болоод, туурвилзүйн өглөг цацлага, эрт цагийн номын гэгээнтнүүд бие биеэ шүтэн бишрэх, баясан дагах, нэгэн агаараар амьсгалах ямар нэгэн учиг сэдлээр холбогдож байгаа нь наад зах нь янаг амрагийн сэдвийн хувьд ч адил, нэг юмны хоёр тал мэт аж. “Төвдийн уран зохиол бол манай уранзохиолд үлэмжхэн нөлөөлсөн юм” (Д.Ёндон “Төвд монголын уран зохиолын харилцааны асуудалд. 1980. 3-р тал) гэснээс үзсэн ч тодорхой.

Уран зохиолын туурвилзүйд “өнгө” гэдэг далд оршигч чухаг зүйл буй. Өнгөө олсон, олоогүй, ийм өнгөөр бичжээ, түүний шүлгийн өнгө аяс сайн гэхчилэн ярилцдаг. “Өнгө” гэдэг нь гадаад тал бус дотоод эрчим хүч, хөдөлгөөн юм. Өнгөний нэгэн агаарт багтдаг гэсэн ойлголт ч байдаг. Тэгвэл энэ хоёр гэгээнтэний холбогдож болох амраг хайрын сэдэвт шүлэг “цоохор” хэмээх Цогт хун тайжийн Дуутын хаданд бичиглэн үлдээснээр:

Дээр тэнгэр хан ахуй хийгээд

Дэлхий дэх хан Богосын аху газар

Дээр доорын ялгаа болбаас

Жаргал хайрлал хоёрын агаар нэгэн буй” гэсэн “**Агаар нэгэн буйзаа**” гэдэг бол чухамхуу өнгө аяс ижил төстэй гэсэн санааг агуулна. Цаад утгаараа гүйцэгдэшгүй утгыг тайлсан философи шиг “Агаар нэгэн буй” гэсэн хосолмол өнгө өнгөө олсон, өөд өөдөөсөө гэрэл чимэг гийгүүлж цацруулсан өнгө аяс, утга санаа төстэй, яруу сонсголон ойролцоо гэхээр бүтээлүүд юм.

Дөрөвдүгээрт: Ерөөс хутагт хувилгаад дан ганц номын жаяг дэгд хүлэгдэлгүй эгэл борог амьдралын жам ёс, сэтгэл зүрхний баяр баясгалан, хуурамч хуудгай олтгой явдал, салхи савир, эр хүн харц буруулахын аргагүй гоо үзэсгэлэн, учралдан дайрах ёстой хувь тавилан, хүний хорвоогийн эрээн бараан, залуу гоо охины урин ааль, урхидах арга заль, хорсол атаархал, тэдний архи сархаданд мунхруулагч мэт шимнусын хороор дамжиж гардаг юм байна гэдгийг Далай лам Цаяннжамцаас мэдэрч, бурхан шашиндаа үнэнч хэдий хувраг ч гэлээ сэтгэл алдран, эм бүсгүй хүн рүү хальтирч, сэтгэлийн зовлон тарчлаан, жаргал баяслыг гарган бичиж болдог юм байна гэсэн урлахуйн жишиг, санамж дохио үүдэл санаа болгон авсан байх нигууртай.

Тавдугаарт: Зохиолч, найрагчид зан араншин гэж бий. Эцсийн эцэст нийгэм цаг үеэ сөрөх араншин бол жинхэнэ туурвигчийн гуйвашгүй шинж юм. Зан ааш ном хоёр зөрдөг. Цаг үеэ эвдэн цойлон гарснаараа зохиолч, яруу найрагч мөнхөд үлддэгийг дэлхийн уран зохиолын түүх гэрчилнэ. Тэд шашны гүн шүтлэгтэн ч гэлээ зүрх сэтгэлийн сэлүүрийг захирч чадаагүй. Элдэв доромжлол, үг ярианаас өчүүхэн ч айж эмээхгүй байна гэдэг жинхэнэ уран бүтээлчийн шалгагдсан үнэн. Энэ хоёр суутан оюуны билэг омогшлоороо “агаар нэгэн” буй. Зан араншинг юу ч хорьж дийлэхгүй. Лам хуврагийн тойрогт өөрсдийгөө царцааж насаа элээх хуврагийн араншин заяасангүй. Тиймээс энэ хоёр эрхэм лам хуврагаараа биш бүтээл туурвилаараа зуунаас зуун дамжин үлдэж чаджээ.

Зан аашны илэрхийлэл дараахи мөрнөөс илэрнэ.

Хөгшин шар банхар минь

Хүнээс дутуугүй ухаант амьтан минь

*Үдшээр ороод явдагийг минь
Үүрээр буцаад ирдэгийг минь бүү дурсаарай (Цаянжамц. Д.Шагдарсүрэнгийн
орч) гэсэн бол*

*Аль эртнээс ерөөлтэй тэр минь
Арайхан хожуу цагт учрав уу
Арван зургаатай нас чинь идэрхэн
Аажмаар ханилсаар зорьсондоо хүрье гэж амьдралын үнэнд гүйцэгдэж сээтгэл
алдарсныг харуул байна.*

Урд өмнөх дүрүүдээсээ “билэг омогшлоороо” “билэг тэргүүлэгчээрээ” “билэг бардамналаараа” “билэг цамналаараа” цолгорон гарсан Цанъянжамц ахайтан Ноён хутагт Данзанравжаагаас 120 жилийн өмнө төрж, энэ завсар түүний шүлэг бүтээлийг унших, түгээх, суралцах хоёр жарны хугацаа өнгөрчээ. Ерөөс манай мөнөөх үлгэр, туульс, домог, хууч, судар ном, шүлэглэлт зохиол энэтхэг, төвдөөс урсан орж ирсэн номын их мөрний ай савын нэгээхэн хэсэг юм. Монгол лам нар Төвд газар орон хийдэд зүтгэн барин сурахдаа төвд лам багшийг шүтэж шавь ордог ч, мөн түүнээс илүү гэгээрч эргээд төвд ламынхаа багш болсон тохиол цөөнгүй. “Төвд багш нарынхаа жишээгээр яруу найраг, түүний мөн чанар, үүрэг зорилго, урнаар сэтгэх найруулах арга хэлбэр, үүх түүх, хууль зүйн өвөрмөц онцлог, уран зохиолын үйл явц, хөгжил хувьслын асуудлыг цөм бүрэнд өгүүлжээ” гэж их эрдэмтэн төвдөч, судлаач Л.Хүрэлбаатар бичиж үлдээжээ. Ийм л зам мөрийг Данзанравжаа туулсан байж таарна.

Хожим хойтынхонд уран бүтээлийн ихээхэн өглөг, санаа сэдэл үлдээснээс гадна болохгүй юмыг болгож, хүсэхгүй юмыг хүсэж, чадмааргүй юмыг чадаж, тэрсэлдэхээргүй юмыг тэрсэлдэж, болгоохгүй юмыг болгоож, амьдралын үнэнийг ганцхан зайцаар харах бус хамаагүй олон хараавчаар харж болохыг, лам хувраг бас ингэж аяглаж болдог юм байна гэдэг үнэнийг илчилснээрээ тухайн үедээ “бузар булай” болж, “нүдэнд үл үзэгдэж, чихэнд үл сонсогдох балайрал” “чихээ бөглөхөөр нүгэлтэн”, “садар самууны бирд” “ичгүүрт амьтан” “нүгэлт тойн” гэж ад шоо үзэгдэн хочлогдсон ч хэдэн зуун дамжин мөнх амьдрах бүтээлээрээ шүлэг найргийг шинэчлэгч, соён гэгээрүүлэгч болсон байна. Данзанравжаагийн “Ичиг ичиг” шүлэгт, “...Аяа бас өдөр хийдэд суугаад, шөнө айл хэсэгч хуврагууд ичиг” гэсэн шиг хэдийгээр гадаад байдлаараа винайн ёсыг хатуу баримталдаг нирваан дүрийг эсгэдэг боловч цаанаа хүмүүний борог амьдралын дунд хутгалдаж байдаг дээд доод бүх хүмүүсийн дотор ил далдаар “Янагийн дуулал” тархаж өнөөд хүрч иржээ. Нуух, хориглох тусмаа түгэж дэлгэрдэг. *Нэг нь Төвдийн шашинлаг яруу найргийн шинэчлэгч бол нөгөөдөх нь Монголын сургамжит сургаалт яруу найргийг өөрчлөн шинэчлэгч мөн.*

Энэ хоёр их хувилгааны хувийн амьдрал, тавилан ерөөл, амьдрал тэмцэл, эрдэм ном, үзэл бодол, үйл лай ойролцоо буюу зарим талаараа бараг давтагдам ижил зүйл ч бий. Цанъянжамц ноорхой ядуу зүдүү хүү байгаад 5 настайдаа төвдийн зургаадугаар Далай ламаар тодорч, Боталын тансаг ордны найман арслант, наран саран хот мандалт алтан ширээнд заларсан бол Данзанравжаа мөн л туйлын ядуу зүдүү, гуйлга зүйлгээр амьдарч ядаж байгаад 8 настайдаа Говийн ноён хутагтын тавдугаар дүрээр тодорч алтан зүмбэрт, найман тахилт ширээнд заларсан түүх, намтартай.

Буддын шашны оройн дээд мандалд суугч гэгээнтний цаад гэгээнтэн мөртлөө садар балайг бичиж, дорд хүмүүсийн ой ухааныг самруулж байна гэж үзээд Төвдийн

дээд лам нар, Манжийн хаанд ад үзэгдэн шийтгэл хүлээлгэхээр Бээжинд хүргэгдэх замдаа өвчнөөр нас барсан бараа бологчийнхоо цогцост өөрийн хувцасаа өмсгөж орхиод зүг буруулан амь зулбасан байна. Данзанравжаа мөн л Их хүрээний дээд лам хуврагуудад бурхны номыг тэрсэлж, “элдэв хачиныг дэлгэрүүлэгч” “галзуу солиотой, архины донтон, гаж номтон” гэх зэргээр гадуурхагдаж Их хүрээнд оруулахгүй хорьж саатуулж байжээ. Ер нь цаг үедээ, тухайн амьдарч байсан нийгэмдээ адлагдаагүй суутан байхгүй.

Өвөр монголын эрдэмтэн Цолмон 2013 онд Улаанбаатарт болсон Д.Равжаагийн мэндэлсэний 210 жилийн ойд зориулсан Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын үеэр “Таны илтгэлийг сонслоо. Миний дотроо бодож санаж явдагтай санаа нэг байна. Би Равжаагийн янаг амрагийн шүлгийг унших бүртээ Цанъянжамц далай ламын “Янагийн дууллыг” санадаг юм. Энэ хоёр их хүмүүний бүтээлийнхоорондын учиг уялдааны тухайд судалгааны өгүүлэл бичих санаатай. Тэрхүү Цанъянжамц далай лам янз бүрийн газраар бадарчилж явсаар манай Өвөр монголын Алшаа нутагт жанч халсан юм шүү дээ. Монголын газар шороонд шингэсэн ганц Далай лам бол Цанъянжамц, цаагуураа нигууртай” гэж хөөрөлдөж байсан нь санагдана.

Долоон настайгаасаа л “Хурмаст тэнгэр” гүр дуу зохиож билгийн нүд нээгдсэн Данзанравжаад утга зохиолын мөнхийн мөн чанар болсон урансайхны хувьд задгай сэтгэж, янаг амраг, хайр сэтгэл, бүсгүй хүний гоо үзэсгэлэнг магтан дуулсан шүлэг бичсэнээрээ хэдэн зууныг дамжсан аугаа их шинэчлэгч, өөрчлөгч болж үлджээ. Мөн Цанъянжамц ийм халуун тэрс сэдэвт шүлэг бичсэнээрээ тэрслүү үзэлтэн болж, Далай лам байтугай далд орж хоргодсон тэнүүлчин, бадарчин шахуу болсоор нэгэн тохиох амьдралаа дуусгажээ.

Магтан дуулах ч бүү хэл бүсгүй хүний гоо сайхныг шүтэн бишрэгч, арга билгийг барилдуулагч болгон дүрсэлсэн нь тухайн нийгмийн лам хуврагийн дунд байтугай сүсэгтэн түмний дунд ч байж боломгүй санаа, үг хэллэгийг төрүүлж чадсан байна. Эр эмийн хоорондох уян сэтгэлийн үл мэдэгдэм харилцааг ч үл зөвшөөрөн “завхай дуу” “завхай явдал” “шалиг дуу” гэж зэвүүрхэн үздэг байв. Дундад зууны шахуу үед эмэгтэй хүнийг ингэж магтан дуулах байтугай гэрийн хоймор гарах эрхгүй, эмэгтэй хүний ном үзэх нь хоттой хонь руу өлөгчин чоно өнгийхтэй адилтгаж, тэднийг “Үйлийн хайч, үнээний дэлэн, үнсний хутгуураас” өөр юманд гар хүрэхийн аргагүй амьтас гэж дордын дорд үздэг байлаа. Нийгмийн ийм бурангуй үзлийн эсрэг өөрийн билэг ухаан, авъяасынхаа хүчдэлийг сөргөлдүүлэн тавьсанаараа хоёр томоохон соён гэгээрүүлэгч бодит уран зохиолын арга, иргэний уран зохиолын үндэс суурийг тавигч, үндэслэгч гэж болохоор байгаа юм.

Үзэл суртлаас ангид урлаг урансайхны чөлөөт сэтгэлгээний тухай бид дөнгөж 90-ээд оноос ярьж эхэлсэн бол яруу найргийн чөлөөт сэтгэлгээ, чөлөөт үзэл санаа, чөлөөт үг хэллэг аль 150 гаруй жилийн өмнө их соён гэгээрүүлэгч Данзанравжаа бий болгож, нэгэн чиглэлтэд тогтсон арга барилыг зоримоогоор өөрчлөн бий болгосныг “яруу найргийн эрс шинэчлэл” гэж үзэх нь зүйтэй.

Цаянъянжамцын хувилгааны шүлгийг Ц.Дамдинсүрэн гуай (“Янагийн дуулал” гэж орчуулсан), эрдэмтэн орчуулагч М.Шагдарсүрэн (“Чихний чимэг хайрын дуун” гэж орчуулсан) нар буулгажээ. Энэ хоёр эрхэм өөр өөрийн онцлогоор мэдэрсэнээ буулгасан нь сонирхол татах тул хоёуланг эшиллээ.

М.Шагдарсүрэн төвд эх, англи, хятад орчуулгыг хооронд нь харьцуулан үзэж аль болохоор хүний сэтгэлийн чавхдасыг хөндөхүйц аядуу зөөлөн шүлэглэлийг урьтал болгосон мэт санагдана. Энэ нь дараахи дөрвөн мөртөөр ойлгогдож байна.

*Эмнэг морийг ууланд хулжихад
Эргүүлж барих уурга байдаг
Энхрий түүний сэтгэл хулжихад
Эргүүлж барих уурга байхгүй*
(Ц.Дамдинсүрэн аругайн орчуулга)

*Эмнэг адуу ууланд хулживч
Цалам бугуйлаар барьж болно
Зангаа эвдэж, хэрүүлч болсон амраг минь
Засарч номхоролгүй бурханд ч дийлдэхээ болилоо*
(М.Шагдарсүрэнгийн орчуулга)

“Зангаа эвдэж, хэрүүлч болсон амраг минь, засарч номхоролгүй бурханд ч дийлдэхээ болилоо” гэсэн үгсийг амнаасаа унагана гэдэг бол “Далай лам” хэмээн дээдлэгдсэн лам хуврагийн хувьд ийм дайрал үгээр хэлнэ гэдэг гагц тэр үедээ бус өнөө үед ч лам хүн ингэж хэлж зүрхлэхгүй бизээ.

Харин хэн бүхний сэтгэлд явдаг, бүгдээрээ мэддэг Ц.Дамдинсүрэн гуайн орчуулгаар бол:

*Эрээн бор цоохор ирвэсийг
Элдэв аргаар номхоруулж болно
Эхнэр гэдэг гээгтэй барыг
Энхрийлэх тусам догшин болно*

гэж буулгасан нь энгийн болоод уран тод, уншихад эвлэг, цээжинд хадгалагдаж үлдэхээр

болсон тул дархлаатай болжээ. Дээрх мөрийг М.Шагдарсүрэн өөр хувилбараар:

*Арслан барс мэт зэрлэг нохойсыг
Амтат хоолоор номхоруулж болдог
Авгай хэмээх эрслэнг хайрлах тусам*

Авир нь догшин хорлон болдог гэж буулгажээ. Үүнийг өөлөх үндэсгүй ч эм барыг “эрслэн” гэдэг ч юмуу төвд эхийг нэлээд ягшмал барьснаар түрүүчийнхээ төдийлөн илүүрхэж чадаагүй шиг санагдана. Тэгээд ч ер нь өлсгөлөн арслан барсад амтат хоол заавал ч хэрэгтэй ч биш байх, мах л бол мах... Мөн энэ алдарт бадгийг:

*Долоолгох юм аманд нь өгвөөс
Ирвэс, барс нохой хялбархан ижилдэж одьюу
Дотоод хүслийн өлөгчин барстай*

Ижилдэх тусам улам дордож одьюу гэж их төвдөч Л.Хүрэлбаатар аругай орчуулсан нь төвд эхийг Шагдарсүрэнгээс ч илүүтэй ягшмал баримталснаар уран чимэглэлт үг хэллэгээр наанатай цаанатай байж болох боловч утгазүйн хувьд хамгийн тод тодорхой гаргасан байх бүрэн магадлалтай. Наад зах нь “Амтат юм”, “Долоолгох юмын” тухайд гэхэд л чанар чансааны хувьд тэнгэр газар шиг ялгаатайг ажиглаж болно. Данзанравжаа ийм санааны “агаар нэгэн буй”

*...Хэнз багахан хээр минь
Хэний л адуунд байгаа бол?
Хилэн зантай авгай минь
Хэний аянд байгаа бол? ...
...Арслан гэгч амьтан
Ариун бусын бөөлжисийг
Эрдэнийн саванд хийвч
Идэхгүй нь магад...*

гэж хүний дотоод сэтгэл рүү өнгийсөн мөртүүд байх юм.

Шашин бурхны үзэл санаа бурангуй мунхруулга болж хувирсан, ертөнцийг өөрөөр үзэх ямар ч аргагүй, хэвшмэл догматик үзэл санаа эвдэршгүй хэрэм мэт бат тогтоод, түүнээс өөрийг бичих байтугай бодох ч эрхгүй үед энэ хоёр гэгээнтэн,

Дээд язгуурт эрхэм хүмүүний

Дэндүү эрхэмсэг гоо охинд дурлах нь

Дээрх модны мөчрөөс бөнжигнөх

Амтат жимсийг хүсэх адилаа...

...Үзэмж төгс нэгэн бүсгүйд сэтгэл алдсанаас

Үдэш шөнөөр нойр хулжин гишүүрэх боллоо

Өдөр нь чамтайгаа учрах боломжгүй

Сэтгэл минь юутай чилнэ вэ?...

(Цаяннжамцын шүлэг. М.Шагдарсүрэнгийн орчуулга) гэсэн бол Данзанравжаа:

Амраг сэтгэлийн туйлыг

Эд яаж мэдэх вэ?

Хагацашгүй амраг минь

Сэтгэлийн төвд буй гэж “Сэргэлэн зант цагаанаа” шүлэгтээ дуулснаараа эрхэм дээд хувраг язгууртан хоёр эрхэмтэн гоо бүсгүйд сэтгэл алдарч, сэтгэлээрээ “нүгэл үйлдэж байгаагаараа” агаар нэг буй.

Амраг охины сэтгэлийг дагавал

Аврал бурханы номтой харшина

Аглаг ууланд дияан хийвэл

Амраг охины сэтгэлтэй харшина (Ц. Дамдинсүрэнгийн орчуулга) гэсэн бол,

...Хамт ойрхон суухад вайдуу зээ

Хагацашгүй амраг

Харин холдон одоход вайдуу зээ

Хуурамч ертөнц болуузай зээ”

...Янаг боловч эвтэй явах хэрэгтэй

Өшөөтэй болбол дуугүй суух хэрэгтэй

...Мойлор модыг тарин суувал

Могой болоод хортон түүнээс гардаг буй

Муу хүнтэй ханилан суувал

Муу болоод мундир түүнээс гардаг буй (Данзанравжаа)гэх зэргийн хорвоогийн эрэн барааныг мэдэрсэн, ертөнц авгайн хуурамч далд мөн чанарыг таньж мэдэрсэн гүн ухаан, бясалгал шингэсэн хайрын мөрүүд тааралдана.

Толгой холбож, гаднаас нь тоочсон цулгай хоосон шүлгийн бүтэц байгууламжийг Бэгзийн Явуухулан жараад онд сэтгэлийн дотоодод нэвчсэн уянгын дүрслэлийг оруулж шинэчлэл хийсэн гэж судлаачид үздэг бол зуу зуун жилийн өмнө яг ийм загварыг Равжаа буй болгосноороо сургаал номлол, бурхан шашны тогтсон хүлцэнгүй бадаглалд өөр ертөнцийн нарыг тусгах адил шууд өөрчлөлт хийжээ. Иймд иргэний уянгын шүлгийн өөрчлөлтийн эхийг он цагийн элэгдэх хугацаагаар урагшуулж харах цаг болсон санагдана.

Лам хуврагийн ёсонд байхгүй, байхын аргагүй чөлөөт сэтгэлгээний буюу хайр сэтгэлийн сэдэвт “Үлэмжийн чанар”, “Найман зүгтээ”, “Тунгалаг огторгуйд”, “Салж ядах сэтгэл”, “Бардам сэргэлэн борыгоо”, “Урьхан хонгор”, “Баян сүмбэр уул”, “Сэргэлэн зант цагаанаа”, “Аяа, тэр минь”, “Шар талын цэцэг”, “Гишгэдэлт хээр” “Дөмөн”, Духтай хурдан хүрэн” зэрэг олон янаг амрагийн сэдэвт утга уянгын

шүлгүүд нь цөм өөрийгөө хайр найргүй эвдсэн чөлөөт сэтгэлгээний ид шид, оюуны эрчим хүчээр бүрэлдэн бий болсон байна. Уран бүтээлд зарчмыг огоорсон чөлөөт сэтгэлгээ шиг эрхэм зүйл үгүй.

Жинхэнэ уран бүтээлчийн чөлөөт сэтгэлгээ л зохиолч, найрагчдад өөрийн хэлбэрийг бүтээх бололцоог олгодог. Ингэснээрээ зохиолч өөрөө болоод бүтээл туурвил нь мөнхөрч үлддэг. Яруу найрагч аль болохоор ихийг үзэж, ихийг үзэж гэгээрч, биеэрээ үзэж туулна гэдэг бол найргийн санаа үүдэн гарах нэгэн чухаг зүйл. Тэгвэл Данзанравжаа Бээжин, Их хүрээ, Эрдэнэ зуу, Алшаа, Долнуур, Амдоо, Утай гээд олон газар орноор хэсүүчилэн явж ихийг үзэж туулжээ. Нөгөө хувраг Цанъянжамц мөн Энэтхэг, балба, төвд, Монгол нутгаар хэрэн хэсэн бадарчилсан байх юм. Энэ бүхнээс төрсөн сэтгэгдэл төрөгдөл шүлгийн санаа болсон нь илэрхий.

...Үнэр сайхан охиныг үзэвч

Үймэх замд зөрсөн нь хайран

Үнэтэй эрдэнийн оюуг оловч

Үлдээж аваагүй нь бас л хайран (Ц.Дамдинсүрэн гуайн орчуулга)

“Үнэр” гэдэг хүртэн мэдрэх мэдрэмжээрээ агаар нэгэн буйг энэ хоёр суут:

...Анхнаас хамт төрсөн

Ариун занданы үнэр шиг

Амрагийн чинь үнэр нь

Аглагаас анхилам ирэхэд

Аргагүй сэтгэл хөдөлгөнө... (Д.Равжаа) гэх буюу үнэртэх эрхтэний мэдрэмж буюу “Үнэр чинь есөн намрын сүмэн өвс адил” гэх мэтийн бүсгүй хүний дотогш орших гоо сайхныг “үнэрээс” эрж хайн дүрслэн илэрхийлдэг уламжлал бол эртний зохиолд дүрслэхийн нэгэн хэсэг болдог. Энэ уламжлал одоо ч буй.

...Тунгалаг огторгуйд үзэхүйд

Тунамал бяцхан тэр минь

Доторхи сэтгэлийн толинд

Тод илхэн ургана... (“Найман зүгтээ”)

...Шар талын цэцэг нь ажнай вайдуу зээ

Сонин сайхан ганхана

Шалгадаг бага чамайгаа

Санах бүрдээ дуулъя (Шар талын цэцэг)

...Үзэсгэлэн огторгуй

гэх зэргээр амраг сэтгэлийн будангуйрал, сэтгэлийн татах хүчээр гаргаж авсан мөр бадгууд Данзанравжаад олон бий.

Сар асгарах мэт жаргал эдэлж

Сайхан чамаасаа хайр нэхээд тослоо

Үхэхийн жам хэмээх үнэн ирэхээс нааш

Үүрд чинийх хэмээн надад амлалаа (Д.Шагдарсүрэнгийн орчуулга)

“Хар элэгтэй боловч

Ханилбал итгэлтэй

Үргэлж ханилахыг санасандаа

Өдөр өнгөрөх нь урт байна (“Баян сүмбэр уул”)

Данзанравжаагийн хайрын сэдэвт шүлгүүдэд бүсгүй хүнийг алдаршуулан дуулсны дотор “Зохист аялгууны толийн” илтийг хориглох чимэг буюу эргэлзэн хорих чимэг гэлтэй хуурамч хоосон чанарыг гаргаж нээсэн шүлгүүд ч тааралдана.

Авгай минь одоо бөөлөхөө зогсоорой

Салахын тамхи барьсуу...

Татгалзахгүйсан бол би

Өдий юундаа ханилах вэ? гэж Данзанравжаа авгай орчлонгийн зан ааш хувирамтгай, урвамтхай ертөнцийг шүүмжлэн шүлэглэжээ. Мэдээж хутагт Данзанравжаагийн шүтэн бишрэгчийн нэг болсон ҮИ Далай лам Цаянжамцын:

“Эмнэг адуу ууланд хулживч

Цалам бугуйлаар барьж болно

Зангаа эвдэж хэрүүлч болсон амраг минь

Засарч номхоролгүй бурханд ч дийлдэхээ болилоо” гэдэгтээ утга санаагаараа **“агаар нэгэн”** буюу.

Бүсгүй хүний бас ил боловч далдын далд нэгэн гоо сайхан бол ялдам зөөлөн инээмсэглэл, инээд баясал юм. Үүнийг ч хоёр суутан хоосон орхисонгүй.

Дун цагаан шүдээ гайхуулан тас тас инээх

Дурламаар сайхан охид руу хариу илгээлээ

Тэдний нэг нь ичингүйрхэн бэргэж

Тийн атлаа тормон нүдээрээ ирмэн дохино. (М.Шагдарсүрэнгийн орчуулга)

...Инээх царай цагаан шүд нь

Илхэн харагдана, олны дундаас

Ирмэх нүдний алаг өнцөг нь

Идэр хүүгийн нүүрийг ширтэнэ. (Ц.Дамдинсүрэнгийн орчуулга)

Цогт багахан чамайгаа

Цогц биеийн дотроос

Цочмог цочмог санах нь

Цоожны өргөс адил... (Данзанравжаа “Бардам сэргэлэн борыгоо”) гэсэн мөрүүд хайр сэтгэлийн жинхэнэ сонгодог мөрүүд байдаг бол,

Амрагаа хайсаар шөнийг сэрээн гарч одлоо

Айлчин ирэх мэт үүр цайж цас бударчээ

Одоо би нуугаад ч яах билээ

Онцгой содон миний мөр тод үлджээ гэсэн сонгодог мөр сэтгэлийн шаналангаараа **“агаар нэгэн буй”**

Ер нь шинэчлэгчийг ерийнхөөс ялгаж таних чанар бол бусдын бүтээлд нөлөөлөгч, хувьсагч мөн чанар юм. Равжаагийн чөлөөт сэтгэлгээний найраг шүлэг ялангуяа тодорхой эзэнгүй “ардын” гэдгээр овоглосон ардын дууны яруу найрагт нөлөөлж ирсэн нь маргаангүй төдийгүй, өөрийнх нь зарим бүтээл ардын дуунаас ялгарахгүйд хүрч байсан удаа бий.

Эл хоёр ламтаны хязгааргүй өргөн сэтгэлгээ, чөлөөт байдал, үзэл суртал номлол болсон шашны нөлөөт сэтгэлгээнээс хэт ангижирсан байдал нь зөвхөн өөрийн гэсэн урлах арга барилыг буй болгожээ. Урд өмнө судар номонд ерөөсөө байгаагүй хайр сэтгэлийн, янаг амрагийн зохист аялгууны шинэ шинэ үг хэллэгүүдийг бүтээжээ. Уян зөөлөн, утга уянгын үг хэллэгүүдийн заримыг дурдваас, “...Удамборын цэцэг мэт, эсэрваагийн эгшигт, зандан модны үнэрт, балын амт нь балайдын сэтгэлийг дараад, хатан төгөлдөр үзэгдэл, эелдэг аалийн чимэгт, үнэнхүү янаг сэтгэлт, жамьянмядаг цэцэг шиг, насан бага тэр минь, цэвэрхэн голиог авгай, мяндсан адил эелдэг зөөлөн ааштай, уран голиог ааш, тэгш багахан чамайгаа зээ, үнэр амт эелдэг, зүйтэй багахан тэр, өнгийн гуа нь үзэмжтэй, гэгээн тунгалаг царай, гиймэл саруул ухаан, лянхуа цэцэг адил, урсгал зөөлөн аашит, нарнаас тунгалаг, навч

цэцгээс эелдэг, учирмагц сэнгэнэсэн, хөөрхөн аальт, балын амт адил, мундашигүй гуалигхан, үзэсгэлэнт охин тэнгэр, уйдашигүй амраг, саран мэт, уяхан эгишиг дуулан нисэгч, шимт цэцэг чи минь, бүсгүй хүний найман төгөлдөр” зэрэг эрхэмсэг найруулгын адилтгал зүйрлэлийг урлахуй, гоо сайхны дээд илэрхийлэл, дурлалын бал амтагдам шимт үг хэллэгүүдийг Дандины “Зохист аялгууны толийн” “бибаа эгшиглэх” мэт аялгуугаар илэрхийлсэн нь ийм үг хэллэгийг тэр үеийн монгол шүлэг яруу найраг тосон хүлээн чадваргүй байсан ч сөрж чадсан төдийгүй, ард олны дунд тун амархан тархсан байна. Данзанравжаагийн олон арван шүлгийг хэдэн арван жилээр цээжилж, хадгалж өвлүүлж ирсэнийг хожмоо айл гэрийн бор авдраас, ардын номч хүмүүний цээжнээс шүүрдэж авсан юм. Өндөр гэгээн Занабазар бүсгүй хүнийг бурханчлан ногоон, цагаан дарь эхийг бүтээсэнтэй адилаар Далай лам Цаяннжамц их говийн ноён хутагт Данзанравжаа хоёр хоёулаа яруу найрсалт, зохист чимэглэлт яруу тансаг үгээр бүсгүй хүнийг бурханчилан сүлдлэн бүтээсэн юм. Ардын дуу шиг маш их дэлгэрсэн “Үлэмжийн чанарыг” эмэгтэй хүний төгс төгөлдөр чанарыг хүмүүний шидэт таван мэдрэхүйн мэдрэмжээр сэтгэлийн дотоод хөдөлгөөнд оршуулж, гадаад дүрийг зураглан гаргасныг энд дурьдах нь илүүц юм.

Цаянжамцын “Чихний чимэг хайрын дуун” хэмээх шүлэглэлд мөн Равжаагаас ялгаагүй бүсгүй хүний гоо үзэсгэлэн заан аашийг дуулсан гэрэлт мөрүүд болох “Анхилам үнэрт амраг минь, цагаан гэрэлт оюу эрдэнэ, дэндүү эрхэмсэг гоо охин, үлэмж төгс бүсгүй, хүрээний нэгэн үзэсгэлэнт охин, энхрий амраг, борхон зүрхийг эзэмдэгч, дээд язгуурт гоо охин, аз жаргалын замд дагуулагч, дун цагаан шүдээ гайхуулагч, дурламаар сайн охин, хөөрхий охины хүсэл, лавай цагаан шүдтэй бүсгүй инээмсэглэхийн ялдамд, хайрлах сэтгэл чинь дэнгийн гэрлээс ч илүү, энхрий амрагтаа нууцлан хэлсэн, янаг хайрт үзэсгэлэнт охин, үнэнч сэтгэлтэй сайхан бүсгүй минь, үлэмж гоо бүсгүй, бүсгүй булбарай биеийг мэдрэвч, үдшийг гэрэлтүүлэх ааль зөөлөн охин минь” гэх зэргээр тэр үед байтугай түүнээс хойдох хэдэн зуунд ч Далай ламын ширээтүүд хэлээгүй дүрслэлт яруу найрсалт үгс Равжаа хутагтын түрүүчийн эшилсэн үгсүүдийн араас шууд залгуулан угсруулан хэлэхэд ялгагдах зүйлгүй нь мөнөөх л “агаар нэгэн буй-гийн” шинж юм.

Хүний сэтгэл хэврэг, хов атаа гэдгийг “агаар нэгэн буйгаар” хэлжээ.

Ижий аавдаа ч итгэж хэлээгүй нууцаа

Энхрий амрагтаа нууцаар хэлсэн юмсан

Амрагаас нь ам дамжин дамжсаар

Атаат дайсны минь сонорт хүрчихсэн байх юм (Орч. Д.Шаг) үүнийг бас Ц.Дамдинсүрэн абугай:

Эцэг эхээс нуусан үгийг

Энхрий чамдаа хэлээд байсан

Энэ мэдээ цаашаа тараад

Эсрэг дайсанд хүрээд байсан гэж орчуулжээ. Орчуулгын ялгааг эрхэм та таних бизээ.

Төвдийн ҮИ Далай лам Цанъянжамц, Говийн Ү Ноён хутагт Дулдуйтын Равжаа нар бол аль алины орныхоо шашны нэгэн хэв шинжит шүлэглэлийг өөрчилж, соён гэгээрүүлэх чөлөөт реализмын үндсийг тавигч, бурхан шашны хэтийдсэн хаагдмал түгжигдмэл байдлаас өөрсдийн билгүүн ухаанаараа цолгойрон гарч, холч мэргэн бодлого, хурц тунгалаг билэг авьяас, амьдралын үнэнд чанагдсан гүн ухаан зэргээрээ хэдэн зуунаар хол тасарч ялгарсан жинхэнэ чөлөөт сэтгэлгээний туурвин бүтээгчид, төвд монголын уламжлалт шүлгийн утгайзүйн уялдаа холбооны “Агаар нэгэн буй”

найрагт цоо шинэ өөрчлөлт, шинэчлэл авчирсан энгүй билэгт, эрдэм чадал төгс, номун ертөнцөд болоод хүмүүний амьдралд гүн шургаж нэвтэрсэн буддистууд гэж үзүүштэй мэт санагдана.

НОМ ЗҮЙ

1. Хүрэлбаатар Л. (2002), “Судар шастирын билэг”, Улаанбаатар.
2. “Гурван зуун шүлэгт” (2013), Улаанбаатар.
3. Мөнхбаяр Б. (2011), “Монголын уран зохиолын тайлбар толь”, Улаанбаатар.
4. Цагаан Д. “Д.Равжаа” яруу найргийн цоморлиг.
5. Цэнджав До. (2013), “Д.Равжаагийн яруу найргийн чөлөөт сэтгэлгээ, шинэчлэгч мөн чанар” өгүүлэл. “Монголын утга соёлын үнэлэмжид Д.Равжаа судлалын эзлэх байр” (Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал), Улаанбаатар.
6. Цаньянжамц (2012), “Чихний чимэг хайрын дуу”, Улаанбаатар. Орч М.Шагдарсүрэн.
7. Ёндон Д. (1980), “Төвд Монголын уранзохиолын харилцааны асуудал”, Улаанбаатар.